



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/242

Улаанбаатар хот

Туул гол дагуу цэвэрлэгээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 63 дугаар тогтоол, 2012 оны 61 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дулааны улирал болж айл өрх, иргэд оршин суугчид зуслан, ногоон бүсэд амарч зугаалж байгаатай холбогдуулан Туул гол дагуух цэвэрлэгээний ажлыг 2017 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс 09 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл зохион байгуулсугай.

2. Бүх нийтийн их цэвэрлэгээнд хяналт тавих ажлын хэсгийг нэгдүгээр, цэвэрлэгээ хийх байршил, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Цэвэрлэгээний ажлыг хариуцсан хорооны нутаг дэвсгэрт зохион байгуулж, харъяа хэлтэс албад, хог хаягдлын үйлчилгээ үзүүлж буй Нийтлэг үйлчилгээний газар-1, 2, 3, 4 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудтай хамтарч цэвэрлэгээ зохион байгуулж хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Цэвэрлэгээнээс гаргасан хог хаягдлыг уртасгасан цагаар тээвэрлэхийг Нийтлэг үйлчилгээний газар 1, 2, 3, 4 /Ж.Мөнх-Од, Д.Нэргүй, Х.Өлзийхорол, Э.Хатанбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

5. Туул гол дагуу цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Дэд бүтэц, хот төлөвлөлт хариуцсан төслийн удирдагч-Засаг даргын орлогч Т.Батцогтод үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВДАВАА